



ЕРӨНХИЙЛӨГЧ Б. ГАНБОЛД



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б. МӨНХЦЭЦЭГ

УДИРДЛАГУУДЫН МЭНДЧИЛГЭЭ

Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн 2013 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, ололт, амжилтаас та бүхэнтэй хуваалцаж байгаадаа баяртай байна.

2013 онд нийгэмлэгийн удирдлага, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт хийгдэж төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх 4 алба байгуулагдаж, дүрмийг Монгол улсын ТББ-ын тухай хууль, Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны дүрэм, бодлогууд болон бусад холбогдох бичиг баримтуудтай нийцүүлэн улам боловсронгуй болгож анх удаагаа дүрмийг хэрэгжүүлэх журмыг боловсруулан мөрдөж байна. Мөн Бэлгийн болон Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн сэдэвчилсэн “Мэдлэгийн өртөө” сургалтыг зохион байгуулах сургалтын удирдамж, материалыг бэлтгэн боловсруулж салбарын тэргүүн, сайн дурын идэвхтэн, үе тэнгийн сургагч зөвлөгчдөө сургаж бэлтгэсэн төдийгүй бүх салбарууд уг удирдамж, материалыг ашиглан сургалт сурталчилгаа явуулах бүрэн боломжтой боллоо. Салбарын тэргүүн, гишүүд, сайн дурын идэвхтэнүүдийг чадваржуулах чиглэлээр 3 удаагийн сургалт зохион байгуулж нийт 77 гишүүд, идэвхтэн хамруулсан нь өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 2 дахин нэмэгдлээ.

Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн тусламж үйлчилгээг нийт 52,621 хүнд үзүүлсэн нь 2012 онтой харьцуулахад 36,6%, эмзэг бүлгийн, алслагдсан нутгийн хүмүүст үйлчилсэн байдал 13,9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Санхүүгийн эх үүсвэр өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 12,8%-иар нэмэгдэж нийт санхүүжилтын 35 хувийг дотоодын эх үүсвэрээс бүрдүүллээ.

Бидний үйл ажиллагааг дэмжиж санхүүгийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн ОУГБТХ болон НҮБ-ын Хүн Амын Сангийн хамт олонд нийгэмлэгийн Удирдах Зөвлөл, гишүүд, дэмжигчдийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье!

Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх хорооны гишүүд, салбарын тэргүүн, сайн дурын идэвхтэнүүд, үе тэнгийн сургагчид, ажилтнууд, хамтрагч түнш байгууллагууд болон биднийг сонгон үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдэдээ онцгойлон талархал илэрхийлье!

Та бүхэнд эрүүл энх, аз хийморь, амжилт бүтээлийн дээдийг хүсье!

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б. ГАНБОЛД

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. МӨНХЦЭЦЭГ

АЛСЫН ХАРАА

Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг нь Бэлгийн ба Нөхөн үржихүйн эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг хүн бүрт чанартай, хүртээмжтэй хүргэхэд туслах талаар тэргүүлэх үүрэгтэй, биеэ даасан төрийн бус байгууллага байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монголчуудын эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, тусламж, үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үзүүлэх явдал юм.

СТРАТЕГИ

1. Өсвөр үеийнхэн, залуучууд- Өсвөр үеийнхэн, залуучуудад тэдний бэлгийн амьдралын эрхэд суурилсан Бэлгийн ба Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, боловсрол, тусламж үйлчилгээг цогцоор нь хүртээмжтэй хүргэх
2. Үйлчилгээний хүртээмж- Хүн бүрт хүний эрхэд суурилсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон гэр бүл төлөвлөлтийн чанартай тусламж, үйлчилгээ ба мэдээллийг тэгш хүртээмжтэйгээр хүргэх
3. ХДХВ/ДОХ//БЗДХ- Хүн амын дунд бэлгийн замаар дамжих өвчний тархалтыг бууруулах
4. Ухуулга нөлөөлөл- Хүний эрхэд үндэслэсэн Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийг орон нутгийн болон үндэсний түвшинд сайжруулах улс төр, нийгэм эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх
5. Үр хөндөлт- Үр хөндөлтийн цогц тусламж үйлчилгээг үзүүлэх замаар давтан үр хөндөлтийн тоог бууруулах

ДЭМЖИХ СТРАТЕГИ


1. Засаглал- Үр дүнтэй засаглал
2. Нөөц бүрдүүлэх- Чанартай үйл ажиллагаа явуулахад шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг нэмэгдүүлэх
3. Чадавхи бүрдүүлэх- Ажилтнууд, сайн дурынхны чадавхийг сайжруулах
4. Мэдлэгийн удирдлага, зохион байгуулалт- Үйл ажиллагаагаа байнга сайжруулах замаар хөрөнгө нөөцөө зөв ашигладаг, сайн жишээгээ бусадтай хуваалцдаг суралцагч байгууллага байна.

ҮНДСЭН ЗАРЧМУУД


1. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх тусламж үйлчилгээ, үйл ажиллагаандаа Монгол улсын болон ОУГБТХ-ны стандартыг мөрдөх
2. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ үйл ажиллагаагаа сайн дурын үндсэн дээр, хувь хүний сонголтыг хүндэтгэн үзүүлэх
3. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх тусламж үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Монгол улсын төр, засгийн болон төрийн бус, олон нийтийн, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн мөн олон улсын байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажиллах
4. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ, үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ арьс өнгө, яс үндэс, нас хүйс, улс төрийн болон шашны итгэл үнэмшил, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, нийгэм эдийн засгийн байдал, газарзүйн байршлаар ялгаварлан гадуурхахгүй жендэрийн тэгш байдлыг хангах
5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд эрхийн талаарх боловсрол тусламж үйлчилгээ, үйл ажиллагааг эмзэг бүлгийн, алслагдсан, орлого багатай, хүмүүст илүүтэй хүргэж ажиллахад анхаарах

ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДАД БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Өсвөр үе, залуучуудад Бэлгийн болон Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн боловсрол, мэдээлэл олгох, зөвлөгөө өгөх 8 төв Орхон аймаг, Булган аймгийн Сайхан сум, Архангай аймгийн Хашаат сум, Өвөрхангай, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Төв аймгуудад ажиллаж байна. 2013 онд эдгээр төвүүд нь Бэлгийн ба НҮЭМ-ийн мэдлэг олгох сургалтыг 6373 залуучуудад явуулсанаас 1998 нь эрэгтэй, 4197 нь эмэгтэй хүүхэд байлаа.



Бэлгийн болон НҮЭМ-ийн зөвлөгөөг нийт 756 залууст утсаар болон ганцаарчилсан хэлбэрээр өгч үйлчиллээ. Үүнээс 530 буюу 70% нь эмэгтэй 226 буюу 30% эрэгтэй байна.



- 15-24 насны нийт 131 хүүхдийг 2-4 удаагийн сургалтанд үе шаттайгаар хамруулж үе тэнгийн сургагч зөвлөгчөөр бэлтгэлээ. Сургагдсан 131 үе тэнгийн сургагч зөвлөгчид нийт 1477 өсвөр үе, залуучуудад Бэлгийн ба НҮЭМ-ийн талаарх сургалт явуулж мэдээлэл

түгээж ажиллалаа.

- Өсвөр үе, залуучуудад зориулсан төвийн үйл ажиллагааг болон зөвлөгч утсаа сурталчлах зорилгоор олон нийттэй харилцах сүлжээ, орон нутгийн телевиз, радиогоор нэвтрүүлэг явуулах, ярилцлага мэдээ өгөх, ток шоу хийх, зар реклам явуулах, сонинд мэдээлэл зөвлөмж бичих зэргээр хэвлэл мэдээллийн сурталчилгаа хийж нийт 5658 хүнд үйл ажиллагаагаа сурталчлах ажлууд зохиолоо.

ЗАЛУУЧУУДЫН ҮЕ ТЭНГИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ:

- Залуучуудын үе тэнгийн боловсролын үндэсний сургагч багш бэлтгэх 4 өдрийн сургалтыг зохион байгуулж Улаанбаатар хот, 12 аймгийн 25 залуусыг үе тэнгийн сургагчаар бэлтгэлээ. Сургалтыг нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, жендэр, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын талаарх боловсрол олгох үе тэнгийн сургалтын оролцооны аргуудыг ашиглан явууллаа.
- Үе тэнгийн сургагч багш бэлтгэх 3 өдрийн сургалтуудыг Увс, Баян-Өлгий аймагт зохион байгуулж аймаг тус бүрт 25 нийт 50 хүүхдийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэлээ. Сургалтыг Залуучуудын үе тэнгийн боловсролын үндэсний сүлжээний зохицуулагч, гишүүд удирдан зохион байгууллаа.
- Өсвөр үе, залуучуудын чиглэлээр ажилладаг 10 гаруй ТББ-уудын төлөөлөлөөс бүрдсэн зохицуулах хороог байгуулан ажиллаж байна.
- Ази номхон далайн Залуучуудын Үе тэнгийн боловсролын Үндэсний сүлжээний төвөөс Тайланд улсын Бангкок хотод зохион байгуулагдсан 5 өдрийн сургалтанд сүлжээний гишүүн Б.Будгараг, Э. Эрдэнэцэцэг нар оролцсон.
- Залуучуудын үе тэнгийн боловсролыг дэмжих 10 хоногийн аянг 2013 оны 12 дугаар сарын 1-10-ны хооронд “БИДНИЙ ХҮСЧБУЙ ДЭЛХИЙ ЕРТӨНЦ” уриан дор амжилттай зохион байгуулж бүсийн төвөөс шилдэг үйл ажиллагаатай улс орноор шалгарсан. Аяны хүрээнд хэвлэлийн бага хурал, нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад 3500 гаруй хүүхдүүд хамарсан хэлэлцүүлэг, хөрөнгө босгох үдэшлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын дунд чин сэтгэлийн уулзалт ярилцлага, мэтгэлцээн зохион байгууллаа. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийттэй харилцах цахим сүлжээ болох Facebook, youtube мөн урeeг.mn сайтаараа дамжуулан байнга мэдээллээ хуваалцаж хүмүүст хүргэж ажилласанаас гадна аяны талаарх мэдээллийн хуудас, үйл ажиллагааг баримтжуулсан 10 минутын телевизийн бичлэг, шторк бэлтгэн хүргэсэн.
- “Залуучуудын үндэсний чуулган”, “Залуусын хөгжилд хамтдаа”, “ХДХВ/ДОХ-ын эсрэг стратеги төлөвлөгөөний дунд хугацааны үнэлгээ”-ний хүрээнд хийгдсэн залуучуудын байгууллагуудын уулзалт, “Ажлын байран дахь бэлгийн дарамт”, Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн сайд нарын 7-р бага хурал зэрэг уулзалт, сургалтанд оролцлоо.

ОЛОЛТ АМЖИЛТ:

- Өсвөр үе, залуучуудад чиглэсэн үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн тэлж байна.
- Залуучуудын Үе тэнгийн боловсролын Үндэсний сүлжээний үйл ажиллагаанд хамрагдах залуучуудын тоо нэмэгдэж байна.



МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, ЗАН ҮЙЛИЙГ ӨӨРЧЛӨХ ХАРИЛЦАА:

- НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Зан үйлийг өөрчлөх харилцаа”-ны 4 өдрийн сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Сургалтанд төрийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн нийт 39 хүн оролцсон. Сургалтыг АНУ-ын Жон Хопкинсийн Их сургуулийн Мэдээлэл Харилцаа Төвийн зөвлөх Патришиа Попп, хөтөлбөрийн ажилтан Утара Барат нар явууллаа. Оролцогчид мэдээлэл харилцааны зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааны стратегийн үндсэн ойлголттой болж нөхцөл байдал зорилгод бүлэгт дүн шинжилгээ хийх, мэдээлэл материал боловсруулах, турших сайжруулах үе шатыг мэдэх, стратеги боловсруулахад суралцлаа.
- Үе тэнгийн сургагч нарт зориулсан “ХДХВ-ийн халдвараас хамтдаа сэргийлье!”, “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх”, “Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд “Надад хэлээч” 3 цуврал гарын авлага боловсруулан тус бүр 3000-3500 хувь хэвлүүллээ.
- Залуучуудын үе тэнгийн боловсролын үндэсний сүлжээний лого бүхий 90 цамц, 10 туг,

- 100 аяга, 500 бал, 300 түлхүүрийн оосор хэвлүүлж үе тэнгийн сургагч нарт түгээлээ.
- Хөдөлгөөнт хүн амд зориулан Бэлгийн болон НҮЭМ-ийн мэдээлэл бүхий “Бид” сэтгүүлийн 2 дугаарыг тус бүр 1500 хувь хэвлүүлэн түгээсэн.
 - БЗДХ, ХДХВ-ийн халдвараас сэргийлэх мэдээлэл бүхий хөзөр 10,000 хувийг хэвлүүлэн түгээсэн.
 - ХДХВ-ийн халдвараас сэргийлэх мэдээлэл бүхий зурган нугалбар 10,000 хувийг хэвлүүлсэн
 - 3 төрлийн 15,000 ш бэлгэвчний хайрцаг хэвлүүлэн түгээлээ.
 - Бэлгийн эрх бол хүний эрх”, “Хэн ч БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөж болно” мэдээлэл бүхий 2 төрлийн зурагт 3000 хувийг хэвлүүлэн түгээсэн.
 - Биеэ үнэлэгч эмэгтэйчүүдэд зориулсан иж бүрдлийг 400 ш, 2 төрлийн тэмдэглэлийн дэвтэр тус бүр 3000 хувь хэвлүүлж тараасан.
 - Өсвөр үеийнхэнд Бэлгийн эрүүл мэндийн боловсрол олгодог Үерхэл LOVE сонин 49-р дугаарыг 100000 хувь, “ҮерхэлLOVE” сэтгүүлийг боловсруулан 18,000 хувь хэвлүүлж нийслэл болон орон нутагт үнэ төлбөргүй тараасан. Мөн www.uyerhel.com, www.mfwa.mn сайтууд дээр онлайнаар тавигдсан.
 - Хөдөлгөөнт хүн амд зориулан БЗДХ-аас сэргийлэх мэдээлэл бүхий нойтон, хуурай салфетка, шүдэнз тус бүр 10,000 хувь хэвлүүлж түгээлээ.
 - Хүрч очих ажилтнуудад зориулсан Бэлгийн болон НҮЭМ-ийн мэдлэг олгох сургалтын үзүүлэн, бэлгэвчний дараалал, эрсдлийн карт тус бүр 66 хувийг боловсруулан хэвлүүлж түгээлээ.




БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

Нийгэмлэг нь Бэлгийн болон Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн тусламж үйлчилгээг

1. Харьяа эмнэлгүүд
2. Сайн дурын идэвхтгэнүүд
3. Нарийн мэргэжлийн эмч нарын явуулын тусламж үйлчилгээ гэсэн үндсэн 3 чиглэлээр үзүүлдэг.


Нөхөн үржихүйн эмнэлгүүдээрээ дамжуулан нийт 34386 хүнд үйлчилгээ үзүүлсэн нь 2012 оны үзүүлэлттэй харьцуулахад 3,6%-иар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1: Нийт үйлчлүүлэгчийн тоо /3 эмнэлгээр/



- 2013 онд орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх шинэ аргуудыг нэвтрүүлэх, өөрийн болон бусад төр, хувийн хэвшлийн эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан “Суулгац тавих, авах арга техник”, “LNG ерөндөг тавих, авах арга техник” зэрэг кредиттэй сургалтуудыг явуулж нийт 40 гаруй хүмүүсийг хамруулж ЭМЯ-тай хамтран “Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян”-ыг зохион байгуулж 4 төрлийн ЖХХ-ийн хангалт авсан зэрэг нь үйлчилгээний төрөл нэмэгдүүлэх, бусад байгууллагатай хамтын ажиллагаагаа сайжруулах амжилттай үйл ажиллагаа болсон. 2013 онд нийт 7599 үйлчлүүлэгчид дааврын уух эм, суулгац, ерөндөг, тариа зэрэг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд –жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн /БНҮЭМ-ЖХХ/ үйлчилгээ , 16227 үйлчлүүлэгчид БНҮЭМ-ЖХХ-ийн бус үйлчилгээ, 10444 үйлчлүүлэгчид бусад эмчилгээ үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө өгч ажилласан байна.

Хүснэгт 2: Эмнэлгээр үзүүлсэн үйлчилгээ



Хүснэгт 3: БНҮЭМ-ЖХХ үйлчилгээ-2013



- БНҮЭМ-ЖХХ үйлчилгээ 2012 онтой харьцуулахад 56%-иар өссөн боловч СДЗШ болон бусад нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний хувь буурсан нь Орхон аймгийн “Ирээдүй” эмнэлэг, Өвөрхангай аймгийн “Залуус” эмнэлэгт 2012 оноос үүссэн хүний

нөөцийн дутагдал, тогтвортой үйл ажиллагааны алдагдлаас шалтгаалан үйлчлүүлэгчийн тоо буурсантай холбоотой.

- Аюулгүй үр хөндөлтийн тусламж үйлчилгээний чиглэлээр олон нийтэд зориулан өртөөчилсөн сургалт явуулах, сургалтын үзүүлэн боловсруулан түгээх зэрэг мэдээлэл, сургалт сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан нь үр хөндөлтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, давтан үр хөндөлтийг бууруулах чиглэлээр өсвөр залуу үеийнхэн болон эмэгтэйчүүдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх үр дүнтэй үйл ажиллагаа байсан. Үр хөндөлтийн үед гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, давтан үр хөндөлтийг бууруулах, үйлчлүүлэгчид зөв шийдвэр гаргахад туслах хамгийн оновчтой арга болох үр хөндөлтийн өмнөх болон дараах зөвлөгөөг үр хөндөлт хийлгэж буй үйлчлүүлэгч бүрт 100% өгч байгаа бөгөөд үр хөндөлтийн дараах хяналт 78% байна.

- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг сар бүр тогтмол авч хэвшүүлсэн бөгөөд эмнэлгийн ажилчдын харьцаа хандлага, ёс зүй, ур чадвар, тохижилт үйлчилгээ зэрэг үзүүлэлтээр 98%-ийн сэтгэл ханамжтай гарсан нь манай эмнэлгүүдийн үйлчилгээний чанарыг тодорхойлох нэг хэмжүүр юм.

ОЛОЛТ АМЖИЛТ

- МГБССН нь “Тэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эмэгтэйчүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх” чиглэлээр тусгай зөвшөөрлийг 2016 онд хүртэл сунгуулсан.

- Өвөрхангай аймгийн “Залуус” эмнэлэгт их эмч ажиллуулахаар гэрээ байгуулан тогтвортой үйл ажиллагааг хангасан.

- Аюулгүй үр хөндөлтийн тусламж үйлчилгээг 3 эмнэлгээрээ дамжуулан үзүүлэх төслийг бичиж батлуулсан нь нийгэмлэгийн эмнэлгийн эмч ажилтнууд болон бусад эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмж, үйлчилгээний чанар сайжруулах олон талын боломжийг нээсэн ажил болсон.



АЛСЛАГДСАН НУТГИЙН ХҮН АМД НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ НАРЫН ЯВУУЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

Архангай аймгийн Хашаат сум, Булган аймгийн Сайхан сум, Баянхонгор, Дорнод, Увс, Дархан-Уул, Орхон, Дорноговь, Сэлэнгэ, Төв аймгууд болон Улаанбаатар хотын салбараар дамжуулан эмнэлгийн явуулын тусламж үйлчилгээг алслагдсан нутгийн болон үйлчилгээ хүртэж чадахгүй байгаа эмзэг бүлгийн хүн амд хүргэсэн ба Халдварт өвчин судлалын Үндэсний төвтэй хамтран Чойр, Мааньтын хорих ангид үзлэг шинжилгээ, сургалт хийсэн.

- Явуулын тусламж үйлчилгээнд нийт 13990 хүн хамрагдсанаас 72 хувь буюу 10127 нь 25 доош насны залуучууд хамрагдсан.
- Нийт 7097 хүнийг шинжилгээ, оношлогоонд хамруулснаас 69 хувь нь ямар нэг өөрчлөлттэй гарсан ба 672 хүнд үнэ төлбөргүй эмчилгээ хийж эрүүлжүүлсэн.
- Эх барих эмэгтэйчүүдийн үзлэгт нийт 2602 эмэгтэй хамрагдсан, 183 эмэгтэйг эмчлэн эрүүлжүүлсэн. 391 хүнд жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслээр үнэгүй үйлчилсэн.
- 1959 хүнийг БЗДХ-ын оношлогоо эмчилгээнд хамруулж 278 үрэвсэлт болон БЗДХ оношилж эмчилгээ хийсэн.
- 178 хүнийг эрэгтэйчүүдийн эмчийн үзлэгт хамруулснаас 60 хүнд зөвлөгөөгөөр үйлчилсэн байна.
- СДЗШ-нд 1930 хүн хамрагдаж, тэмбүүгийн түргэвчилсэн оношлуур болон лабораторийн шинжилгээнд 2773 хүнийг хамруулж 174 хүнд тэмбүү оношилж 148 хүнийг эмчлэн эрүүлжүүлсэн ба 26 хүнийг дараагийн шатны оношлогоонд шилжүүлэв.
- Дотрын эмчийн үзлэгт 2146 хүнийг хамруулсан үүнд зүрх судас, ходоод гэдэс, бөөрний өвчлөлтэй, элэгний архаг үрэвсэлтэй оношлогдсон ба 245 хүнийг эмчлэн эрүүлжүүлсэн байна.
- 1222 хүүхдийг хүүхдийн эмчийн үзлэгт хамруулж, зөвлөгөө өгсөн ба 63 хүүхдэд нэмэлт тэжээл өгсөн суурь өвчтэй хүүхдүүдийг орон нутгийн эмчийн хяналтанд оруулсан.
- 46 хүнийг шүдний эмчийн үзлэгт хамруулснаас 40 хүнд эмчилгээ хийсэн.
- Нийт 259 хүнийг мэдрэлийн эмчийн үзлэгт хамруулж шаардлагатай хүмүүсийг дараагийн шатны эмнэлэгт шилжүүлсэн .
- Явуулын тусламж үйлчилгээг үзүүлэхдээ орон нутгийн 328 залуучуудыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхээр 6-8 цагийн сургалтанд хамруулж 427 хүнд мэдээлэл өгсөн байна.


ОЛОЛТ АМЖИЛТ

- 2012 онтой харьцуулахад үйлчилгээ хүргэсэн хүний тоо 470%-иар буюу 4,7 дахин нэмэгдсэн байна.

САЙН ДУРЫН ИДЭВХТНҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Орон нутаг дахь салбаруудын сайн дурын идэвхтнүүдээрээ дамжуулан нийт 5130 хүнд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийсэн ба 3689 хүнд зөвлөгөө, жирэмслэхээс хамгаалах эм, бэлгэвчээр үйлчилсэн байна. Энэ нь өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад мэдээлэл сургалт сурталчилгаанд хамрагдсан хувь 16,8 бэлгийн амьдрал, НҮЭМ-ийн зөвлөгөө, жирэмслэхээс хамгаалах эм бэлгэвчээр үйлчилсэн хувь 43,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Явуулын үйлчилгээ болон сайн дурын идэвхтнүүдийн үйлчилсэн хүний тоо, сүүлийн 3 жилээр



ХДХВ/ДОХ/БЗДХ

- Дэлхий нийтээрээ ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарлаа хандуулах өдрийг угтан Монголын Оюутны Холбоотой хамтран Улаанбаатар, Дархан-Уул, Орхон зэрэг аймаг дахь их дээд болон МСҮТ-ийн 30 гаруй их дээд сургуулийг хамарч “Залуучууд аа! БЗДХ болон ХДХВ, ДОХ-оос хамтдаа сэргийлье! аяны хүрээнд нийт 5500 оюутан залууст ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээсэн.
 - Кино Урлагийн Дээд Сургуультай хамтран Монгол улсын төрийн хошой шагналт УГЗ Д.Намдагийн зохиол “ Амь амьдралын үнэ” жүжгийг Хүүхдийн ордноо тоглож хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан.
 - Өвөрхангай, Булган аймгийн Сайхан сум, Өмнөговь аймаг дахь салбарууд нийт 421 залуучуудыг сургалтанд хамруулж, 579 хүнд мэдээлэл сурталчилгаа явуулж 500 хүнээс НҮЭМ-ийн мэдээллийн талаар судалгаа авсан байна.
 - “ХДХВ/ДОХ-ын асуудлаарх үндэсний 6-р чуулган”-нд оролцож, 23 төрлийн 4282 мэдээлэл сурталчилгааны материал түгээсэн.
 - ХДХВ/ДОХ-ын чиглэлээр ажилладаг байгууллагуудын талаарх мэдээллийн бааз үүсгэх зорилгоор 2013 оны 12-р сарын 27-нд холбогдох төрийн болон ТББ-уудын дунд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
 - Сайн Дурын Зөвлөгөө Шинжилгээнд нийт 2180 хүн хамрагдсанаас 177 хүн 3 эмнэлэгээр, 1930 хүн явуулын тусламж үйлчилгээгээр, 73 хүн 12 сарын 1-нд буюу Дэлхий нийтээрээ ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарлаа хандуулах өдрийн үйл ажиллагаагаар хамрагдсан байна.
- Ололт амжилт:
- Урлагаар дамжуулж залуучуудад БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх боловсрол мэдээлэл олгох ажил илүү үр дүнтэй байна.
 - ХДХВ/ДОХ-ын чиглэлээр ажилладаг байгууллагуудын мэдээллийн сан үүсгэх ажлыг санаачлан эхлүүлсэн.



DOA 10 Days of Activism

Y-PEER Youth Peer Education Network Mongolia

“БИДНИЙ ХҮСЧ БҮЙ ДЭЛХИЙ ЕРТӨНЦ”

сэдэвт гар зураг болон захидлын уралдаан

Та эргэн тойрны чинь орчин дэлхий ертөнц ямар байгаагай гэж хүсч байна вэ? Та өөрийн нөхөн үржихүйн эрхээ хамгаалж, эгэлж чадаж байна уу? Өөрийн бодлоо гар зургаар болон захиагаар илэрхийлээрэй.

Бид таны зурганд шаардлага тавихгүй
Бид таны захианд хэмжүүр тогтоохгүй.

Гар зураг болон захидлын шилдэг 2,2 бүтээл тус бүр мөнгөн шагнал

Бүтээл хүлээн авах хугацаа:
2013 оны 12-р сарын 8-ны 18.00 цаг хүртэл
Монголын гэр бүл сайн сайхны нийгэмлэгийн 2 давхарт, мөн
peer.mongolia@gmail.com хаягаар хүлээн авна.
Утас 9961-9144. 8809-0729. 8895-6801

“YEPKЭЛ” сэтгүүл бүтээлээ нийтлүүлэх эрх.
Уралдаанд оролцогч бүр “Y-Peer” -ийн гарын бэлэгтэй.



ЗАСАГЛАЛ:

- Нийгэмлэгийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор удирдлага, зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт хийгдэж төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх 4 алба байгуулагдаж, ажилтнуудын ажил үүргийг илүү боловсронгуй тодорхой болгосон.
- Нийгэмлэгийн дүрмийг Монгол улсын ТББ-ын тухай хууль, ОУГБТХ-ны дүрэм, бодлогууд болон бусад холбогдох бичиг баримтуудтай нийцүүлэн өөрчлөлт хийж, хэлэлцүүлж, улам боловсронгуй болгосон ба анх удаагаа дүрмийг хэрэгжүүлэх журмыг боловсруулан нийгэмлэгийн удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталж мөрдөж байна.
- Нийгэмлэгийн дүрмийн хүрээнд Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх хорооны сонгууль зохион байгуулагдаж шинээр Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх хорооны гишүүд сонгогдсон. Удирдах Зөвлөлийн тэргүүн буюу нийгэмлэгийн Ерөнхийлөгчөөр Дорнод аймаг дахь салбарын гишүүн, Дорнод аймаг Монголын Улаан Загалмайн хороон дарга Б. Ганболд сонгогдлоо. Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний 10 нь буюу 71% нь эмэгтэй, 4 буюу 29% нь эрэгтэй, 14,2% нь 25-аас доош насны хүмүүс байна. Гүйцэтгэх хорооны 3 нь буюу 43 % нь эрэгтэй, 4 нь буюу 57 % нь эмэгтэй хүмүүс ба 28 % нь 25-аас доош насны насны хүмүүс байна.
- Нийгэмлэгийн санхүүгийн болон хүүхэд хамгаалалын бодлого, хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж шинээр ёс зүйн дүрмийг боловсруулсан.
- Шинээр сонгогдсон Удирдах Зөвлөл 3 жилийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.
- ОУГБТХ-ны дэмжлэгтэйгээр 2011-2015 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний дунд хугацааны үнэлгээг хийж Удирдах Зөвлөл, салбарын тэргүүн нарт танилцуулсан.
- Нийгэмлэгийн гэрчилгээг шинэчлэн салбаруудыг гэрчилгээжүүлж, албан ёсны данстай болголоо.
- 2013 оны эрсдлийн үнэлгээг хийж 2014 оны эрсдлийг тодорхойлж төлөвлөлөө.

ОЛОЛТ АМЖИЛТ:

- Нийгэмлэгийн удирдлага зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэж сайжирсан.
- Нийгэмлэгийн дүрмийг шинэчлэн дүрмийг хэрэгжүүлэх журмыг анх удаагаа боловсруулан мөрдөн ажиллаж байна.




ЧАДАВХИ БҮРДҮҮЛЭХ:

Гишүүд, сайн дурынхан болон ажилтнуудын чадавхийг сайжруулах зорилгоор:

- 2013 оны 9 дүгээр сарын 13-нд салбаруудын тэргүүн болон санхүүч нийт 26 хүнд “нийгэмлэгийн бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулах” чиглүүлэх нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан ба оролцогчдын мэдлэгийн түвшин 36 хувиар өссөн байна. Мөн НҮЭМ-ийн сэдэвчилсэн мэдлэгийн өртөө сургалтыг зохион байгуулж салбаруудад сургалт зохион байгуулах өртөөчилсэн самбарууд олгосон.
- Шинээр сонгогдсон Удирдах Зөвлөлийн гишүүдэд нийгэмлэгийн болон Олон Улсын Гэр Бүл Төлөвлөлтийн Холбооны бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулах чиглүүлэх нэг өдрийн сургалтыг зохион байгууллаа.
- 2013 оны 11-р сарын 12-14-ны хооронд 13 салбарын сайн дурын идэвхтнүүд болон өсвөр үе залуучуудын төвийн зохицуулагчдад зориулан 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 29 хүн хамрагдаж мэдлэгийн түвшин 42 хувиар өссөн.
- Эмнэлгийн ажилтнуудад зориулан “Үйлчилгээний статистик тайлан мэдээ” сэдвээр 2013 оны 12-р сарын 25-нд 8 цагийн сургалтыг зохион байгуулсан.
- Салбаруудад 3 жилийн тайлан сонгуулийн хурлын зардлыг олгосон.
- Нийгэмлэг үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг угтан салбарууд, гишүүд, сайн дурын идэвхтэнүүд, ажилтнууд, залуу гишүүдийг идэвхжүүлэх урамшуулах зорилгоор 10 сарын хугацаатай уралдаан зарлалаа.
- Ажилтнуудад зориулан “Байгууллагын соёл, ёс суртахуун”, “Нийгэмлэгийн санхүүгийн баримт хөтлөлт, журам”, “Галын аюулгүй байдал”, “ХДХВ, ДОХ-ын Үндэсний стратегийн дунд хугацааны үнэлгээний үр дүн, ХДХВ, ДОХ-ын өнөөгийн байдал”, “эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” зэрэг сэдвийн хүрээнд 5 цагийн сургалт зохион байгууллаа.
- More Stepns, Бизкон аудит олон улсын болон дотоодын аудитын байгууллагуудын хөндлөнгийн аудит хийгдэж санхүүгийн журам, тарифыг шинэчлэн холбогдох зөвлөмжийг биелүүлж ажиллаж байна.

Сургалтанд хамрагдсан гишүүд, сайн дурын идэвхтэн, ажилтнууд сүүлийн 3 жилээр



ОЛОН УЛСЫН ХУРАЛ, СУРГАЛТ, СЕМИНАР:

- ОУГБТХ-ны Зүүн ба Зүүн Өмнөд Ази Далайн бүсийн төвөөс Малайз улсын Куала Лампур хотод 2013 оны 4-р сарын 23-26-ны хооронд зохион байгуулсан “Статистик тайлан мэдээний чанар” сэдэвт сургалтанд хөтөлбөрийн менежер Г.Гэрэлмаа оролцлоо.
- ОУГБТХ-ны Зүүн ба Зүүн Өмнөд Ази Далайн бүсийн төвөөс Индонез улсын Бали хотод 2013 оны 7 дугаар сарын 3-7-ны хооронд зохион байгуулсан Бүсийн зөвлөлийн хуралд Ерөнхийлөгч Л. Оюунаа, Дэд Ерөнхийлөгч Б. Ганболд нар, гүйцэтгэх захирлуудын хуралд гүйцэтгэх захирал Б. Мөнхцэцэг, залуучуудын чуулга уулзалтад Өвөрхангай аймгийн залуу гишүүн, үе тэнгийн сургагч Б. Билэгжаргал нар оролцлоо.
- НУБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хөтөлбөрийн менежер Ш.Галбадрах 2013 оны 10-р сарын 21-ээс 11-р сарын 1-ний хооронд Зан үйлийг өөрчлөх харилцааны сургалт, хөтөлбөрийн менежер Ч. Сэлэнгэ 2013 оны 11-р сарын 18-24-ны хооронд Ази Номхон Далайн бүсийн ДОХ-ын Олон улсын 11-р хуралд Тайланд улсын Бангкок хотноо тус тус оролцсон.
- ОУГБТХ-ны Зүүн ба Зүүн Өмнөд Ази Далайн бүсийн төвөөс Малайз улсын Куала Лампур хотод 2013 оны 11-р сарын 30-аас 12-р сарын 5-ны хооронд зохион байгуулсан өсвөр үе, залуучуудын чадваржуулах сургалтанд захирлын туслах, нарийн бичиг С.Эрдэнэтунгалаг оролцлоо.



БУСАД:

- Ажлын таатай орчин бүрдүүлэх, материаллаг бааз бэхжүүлэх зорилгоор нийгэмлэгийн ажлын алба болон Гэр бүл эмнэлэгт нийт 9 248 000 төгрөгийн засвар тохижилт хийж 17,809,100 төгрөгийн өртөг бүхий ширээний болон зөөврийн компьютер, ширээ сандал, утасны аппарат мэдээллийн самбар, камержуулалт, цаг бүртгэлийн систем зэрэг тохижилт хийгдсэн.
- Нийгэмлэгийн танилцуулгыг шинэчлэн боловсруулж 5000 хувь хэвлүүлэн түгээлээ.
- Орхон аймаг дахь салбарт 1.409.500 төгрөгийн засварын санхүүжилт олголоо.
- Баянхонгор, Сүхбаатар аймаг дахь салбаруудад 2,959,400 төгрөгийн өртөг бүхий иж бүрэн ширээний компьютер, принтер олголоо.
- Филиппин улсад болсон хар шуурганд өртсөн Филиппин улсын нийгэмлэгт салбарууд, ажилтнууд, гишүүдийн дэмжлэгтэйгээр 1000 ам доллар хандивлалаа.
- Ажлын алба болон Гэр бүл эмнэлгийн ажилтнуудыг Дорнод аймаг дахь салбар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асрах төвийн үйл ажиллагаатай танилцуулж, БНХАУын Манжуур хоттой танилцуулсан.



БАЛАНС

Тайлант хугацаа: 2012/12/31 ба 2013/12/31-ий байдлаар

	(төгрөгөөр)	
	01/01/2013	31/12/2013
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8 318 741	25 239 969
Дансны авлага	4 278 035	
Бараа материал	89 913 260	89 877 748
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
Эргэлтийн хөрөнгө	102 510 036	115 117 717
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	434 548 093	434 548 093
Хуримтлагдсан элэгдэл	(40 964 839)	(56 278 002)
Бусад хөрөнгө	521 570 806	515 873 421
Хуримтлагдсан элэгдэл	(132 030 564)	(136 261 124)
Биет бус хөрөнгө	3 040 000	3 040 000
Хуримтлагдсан элэгдэл	(308 380)	(379 100)
Эргэлтийн бус хөрөнгө	785 855 116	760 543 288
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	888 365 152	875 661 005
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Татвар хураамжын өглөг	-	
Дансны өглөг	33 043	24 277
Цалингийн өглөг	2 161 703	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2 194 746	24 277
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	23 321 122	18 531 505
Урт хугацаат өр төлбөрийн дүн	23 321 122	18 351 505
Цэвэр хөрөнгө		
Нөөц а)Хязгаарлалттай	3 872 134	537 936
б) Хязгаарлалтгүй	858 977 150	871 100 021
Хуримтлагдсан үр дүн		(14 352 733)
Цэвэр хөрөнгийн дүн	862 849 284	857 285 223
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН	888 365 152	875 661 005

ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2011/12/31 ба 2012/12/31-ий байдлаар

(төгрөгөөр)

	2012	2013
Үйл ажиллагааны орлого		
Хөтөлбөр төслийн орлого	300 836 666	204 725 155
Бэлэг хандив тусламжын орлого	500 000	1 423 599
Бусад орлого	212 870 160	388 568 400
Үйл ажиллагааны орлогын дүн	514 206 826	594 717 154
Үйл ажиллагааны зардал		
Төсөл хэрэгжүүлсний зардал	216 615 639	265 233 967
Цалин хөлс шагнал	219 287 906	188 919 804
Нийгмийн даатгалын зардал	23 973 374	20 452 747
Ашиглалтын зардал	22 842 572	22 498 513
Түрээсийн зардал	-	
Албан томилолтын зардал	6 094 261	15 879 440
Элэгдэлийн зардал	38 839 225	44 135 093
Шуудан холбооны зардал	8 686 295	7 145 267
Шатахуун сэлбэг хэрэгсэлийн зардал	26 389 012	25 189 577
Зээлийн хүүгийн зардал	5 535 902	4 563 183
Бусад зардал	25 595 387	17 088 984
Татварын зардал		
Үйл ажиллагааны зардлын дүн	581 907 710	611 106 575
Үндсэн бус үйл ажиллагааны олз (гарз)		
Валютын ханшны өөрчлөлтөөс үүссэн олз (гарз)	(973629)	2 036 687
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН	(68 674 513)	(14 352 733)

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ 2010-2013 ОНЫ 9 САР ХҮРТЭЛ

Үндэсний зөвлөлийн гишүүд

1. Л.Оюунаа-Ерөнхийлөгч/Улаанбаатар хот/
2. Д.Ганболд-Дэд ерөнхийлөгч/Дорнод аймаг/
3. Б.Батцэцэг-Сангийн түшмэл/Архангай аймаг, Хашаат сум/
4. Д.Дулмаа-Нарийн бичгийн дарга/Увс аймаг/
5. Т.Алтансүх-ҮЗ-ийн гишүүн /Булган аймаг-Сайхан сум/
6. В.Нарантуяа-ҮЗ-ийн гишүүн/Баянхонгор/
7. Г.Туул-ҮЗ-ийн гишүүн/Дархан-Уул аймаг/
8. Ч.Баярсайхан-ҮЗ-ийн гишүүн/Дорноговь аймаг/
9. А.Баясгалан-ҮЗ-ийн гишүүн/Орхон аймаг/
10. Н.Нарангэрэл-ҮЗ-ийн гишүүн/Өмнөговь аймаг/
11. А.Эрдэнэтунгалаг-ҮЗ-ийн гишүүн/Өвөрхангай/
12. С.Тунгалаг- ҮЗ-ийн гишүүн/Сүхбаатар аймаг/
13. С.Нансалмаа-ҮЗ-ийн гишүүн/Төв аймаг/

Гүйцэтгэх хорооны гишүүд

1. Л.Оюунаа-Ерөнхийлөгч/Улаанбаатар хот/
2. Д.Ганболд-Дэд ерөнхийлөгч/Дорнод аймаг/
3. Б.Батцэцэг-Сангийн түшмэл/Архангай аймаг, Хашаат сум/
4. Д.Дулмаа-Нарийн бичгийн дарга/Увс аймаг/
5. Ч.Баярсайхан-ҮЗ-ийн гишүүн/Дорноговь аймаг/
6. Э.Эрдэнэбулган- ҮЗ-ийн гишүүн/Орхон аймаг/
7. Э.Баярцогт- ҮЗ-ийн гишүүн/Өмнөговь аймаг/

УДИРДАХ ЗӨВЛӨЛ 2013 ОНЫ 09 САРААС ОДООГ ХҮРТЭЛ

Удирдах зөвлөлийн гишүүд

1. Б.Ганболд-Ерөнхийлөгч /Дорнод аймаг/
2. Б.Оюун-эрдэнэ-Дэд ерөнхийлөгч /Дорноговь аймаг/
3. Б.Ундармаа-Сангийн түшмэл/Дархан-уул аймаг/
4. М.Санжаасүрэн-Нарийн бичгийн дарга/Орхон аймаг/
5. Н.Дарханбаяр-Архангай аймаг Хашаат сум
6. Э.Гүнжинлхам-Баянхонгор аймаг
7. Э.Цэдэндаш-Төв аймаг
8. Д.Давааням-Булган аймаг Сайхан сум
9. А.Гэрэлмаа-Сэлэнгэ аймаг /ажиглагч/
10. Б.Цаямаа-Өвөрхангай аймаг
11. Р.Тунгалаг-Өмнөговь аймаг
12. Д.Туяа-Сүхбаатар аймаг
13. С.Гэрэлмаа-Увс аймаг
14. Б.Дангаасүрэн-Улаанбаатар хот

Гүйцэтгэх хороо

1. Б.Ганболд-Ерөнхийлөгч /Дорнод аймаг/
2. Б.Оюун-эрдэнэ-Дэд ерөнхийлөгч /Дорноговь аймаг/
3. Б.Ундармаа-Сангийн түшмэл /Дархан-уул аймаг/
4. М.Санжаасүрэн-Нарийн бичгийн дарга /Орхон аймаг/
5. Н.Дарханбаяр-Архангай аймаг Хашаат сум
6. Э.Гүнжинлхам-Баянхонгор аймаг
7. Э.Цэдэндаш-Төв аймаг

Гүйцэтгэх захирлын ажлын алба-2013

1. Гүйцэтгэх захирал:
Ч. Сэмжидмаа- 1996-03 сараас 2013-01.15 хүртэл
Г. Гэрэлмаа 2013.01.15-наас 2013.05.01 хүртэл түр орлон гүйцэтгэгч
Б. Мөнхцэцэг 2013.05.01-нээс
2. Ч. Ганбаатар- Санхүүгийн менежер
3. Г. Гэрэлмаа- Хөтөлбөрийн менежер /ХДХВ/ДОХ, салбарууд, сайн дурын идэвхтэн, явуулын тусламж үйлчилгээ хариуцсан/
4. Г. Гэрэлмаа, 2012.12-2013.07 сар хүртэл /өсвөр үе, залуучуудын төсөл хариуцсан/
5. Ш. Галбадрах 2013 оны 7.15-наас -Хөтөлбөрийн менежер/өсвөр үе, залуучуудын төсөл хариуцсан/
6. Д. Энх-Оюун, хөтөлбөрийн менежер 2013 оны 6 сар хүртэл,
7. Ч. Сэлэнгэ -2013 оны 8.1-нээс -Хөтөлбөрийн менежер /эмнэлгүүд хариуцсан/
8. С. Эрдэнэтунгалаг- Захирлын туслах, нарийн бичиг, хэвлэл мэдээллийн ажилтан
9. Э. Оюун-Эрдэнэ, санхүүгийн туслах ажилтан ,2013 оны 4 сар хүртэл
10. Ц. Батцэцэг –нярав, 2013 оны 6.1-нээс
11. Ж. Батболд -Жолооч

Улаанбаатар хот “Гэр бүл” эмнэлгийн ажилтнууд

1. Т. Энхтунгалаг-их эмч
2. Ч. Цэцэгмаа-бага эмч
3. А. Дөмөгмаа-угтагч, зөвлөгч
4. Г. Алтансүвд-асрагч, үйлчлэгч

Өвөрхангай аймаг “Залуус” эмнэлгийн ажилтнууд

1. Ш. Оюунчимэг-салбарын менежер 2013 оны 4 сар хүртэл
2. Д. Ренчиндулам-их эмч
3. Т. Даваадолгор-угтагч, зөвлөгч
4. Н. Лусмаа-асрагч, үйлчлэгч



PRESIDENT B. GANBOLD

WELCOME MESSAGE FROM THE PRESIDENT AND EXECUTIVE DIRECTOR



EXECUTIVE DIRECTOR
B. MUNKHTSETSEG

Dear Friends,

The year 2013 was a remarkable period that came with abundance in our activities and achievements for MFWA and we are delighted to share our accomplishments in this report.

We revised our management structure and established four new additional project management units. MFWA constitution was revised to be upgraded in line with the Mongolian Law on NGOs, IPPF rules and policies as well as other related documents, and the first-time ever constitution implementation procedure was developed and has been followed since. We developed sexual and reproductive health thematic session station board training guidelines with its visual portable boards and conducted trainings among all the branch leaders, community based distributors and peer educators. We are proud that all the branches have the capacity to conduct these station board trainings independently. Achievements were also made in capacity building trainings through two-fold increase in comparison with the year of 2012 that totaled our training sessions to three covering 77 members.

